



**МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 7
Утас: 32-71-99, Факс: (976-11) 32-21-47
<http://www.ulaanbaatar.mn>

2020. 02. 07 № *02-01/669*

танай _____-ны № _____-т

**НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН
ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД**

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
“Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/166
дугаар захирамжийг хүргүүлж байна. Захирамжийн
хэрэгжилтийг хангаж ажиллана уу.

Хавсралт 8 хуудастай.

ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН АСУУДАЛ
ХАРИУЦСАН НЭГДҮГЭЭР
ОРЛОГЧ **Ж.БАТБАЯСГАЛАН**





НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/166

Улаанбаатар хот

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
талаар авч хэрэгжүүлэх зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 39 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Авто тээврийн шалган нэвтрүүлэх Багануур дүүрэг Хэрлэнгийн гүүр, Багахангай дүүрэг Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо, Баянзүрх дүүрэг Хонхор, Хан-Уул дүүрэг Өлзийт, Морингийн даваа, Сонгинохайрхан дүүрэг Эмээлт, Баруунтуруу, Чингэлтэй дүүрэг Ар гүнт зэрэг байнгын ажиллагаатай товчоодод Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн байгууллагыг нэмэлтээр ажиллуулсугай.

2. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор нэвтэрч байгаа зорчигчдод Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүйтгэл хийж ажиллах түр журмыг нэгдүгээр, мэргэжлийн байгууллагуудын ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг зарим халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.1. Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Д.Ядамдорж/, Нийслэлийн Онцгой байдлын газар /Ж.Чүлтэмсүрэн/, Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар /Д.Дашдорж/-т;

3.2. Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ болон хоол үйлдвэрлэл үйлчилгээ, зах, худалдааны төвүүдэд цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэлийг тогтмол хийж, ажиллагсад амны хаалт зүүж, гараа тогтмол ариутгаж ажиллах талаар зөвлөмж өгөх хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Дүүргүүдийн Засаг дарга нарт;

111020000744

3.3.Мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүн худалдан борлуулдаг хүнсний зах, худалдааны төвүүдэд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Мал эмнэлгийн газар /А.Нарантуяа/-т;


3.4.Мал, амьтны гаралтай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, золбин муур нохой устгалын ажлыг зохион байгуулах, сэг зэмийг төвлөрсөн хогийн цэгт устган халдваргүйтгэл хийх, орчны эрүүл ахуйн хяналтыг чангатгах, хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/, Нийслэлийн Мал эмнэлгийн газар /А.Нарантуяа/, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т;

3.5.Орон нутгийн Төмөр зам, агаарын тээвэр, хот хоорондын зорчигч тээврийн байгууллагуудаар үйлчлүүлж байгаа иргэдийн биеийн эрүүл мэндийн хяналт тандалтын талаарх мэдээ, мэдээллийг мэргэжлийн байгууллагуудад шуурхай дамжуулж ажиллахыг Нийслэлийн Тагнуулын газар /А.Баярсайхан/-т;

3.6.Томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусын халдвар, шувууны томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулж байгаа бүхий л үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр өргөн хүрээнд мэдээлж, иргэдийн сонор сэрэмжийг дээшлүүлэхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т.

4.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч /Ж.Батбаясгалан/-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ



С.АМАРСАЙХАН

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
02 сарын 06-ны өдрийн
А/1166 дугаар захирамжийн
4 дүгээр хавсралт

Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай
товчоонд дээр шинэ коронавирусын халдвараас сэргийлэх,
илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүйтгэл хийх түр журам

Нэг. Үндэслэл

1. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 19 дүгээр албан даалгавар, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/32 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 108 дугаар захирамж, Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны нийслэлийн нэгдсэн төлөвлөгөө, Нийслэлийн Онцгой комиссын хурлын 02 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодод шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүйтгэл хийх үйл ажиллагааг энэхүү түр журмаар зохицуулна.

2. Авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоонд ажиллаж байгаа эрүүл мэнд, онцгой, цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан, албан хаагчид нь Монгол Улсын Шадар сайдын А/08 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2015 оны “Хүний коронавируст халдварын тандалт, оношилгоо, эмчилгээ, халдвараас сэргийлэх арга хэмжээний заавар” 242 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, 2018 оны А/438 дугаар “Томуугийн цар тахлын бэлэн байдал, хариу арга хэмжээний удирдамж”, 2019 оны “Заавар батлах тухай” 537 дугаар тушаал, ДЭМБ-ын түр зөвлөмж болон энэхүү журмыг мөрдөж ажиллана.

Хоёр. Хамрах хүрээ

1. Нийслэлийн Авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоогоор нэвтэрч байгаа тээврийн бүх хэрэгсэлд үзлэг шалгалт хийгдэнэ.

Гурав: Халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүйтгэл хийх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт

1. Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоодын 24 цагийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагын хяналт шалгалтыг эрүүл мэндийн байгууллагын төлөөлөл ахалж ажиллах бөгөөд мэдээ, мэдээллийг өглөө бүрийн 09:00 цагт Нийслэлийн Засаг даргын Шуурхай штабын 324207 утсанд мэдээлнэ.

2. Нийслэлийн Эрүүл мэндийн газар нь доорх бэлтгэл ажлыг хангаж, хяналтад ажиллах эмч, эмнэлгийн ажилтан, мэргэжилтний нэрс, ажиллах өдөр бүхий хуваарийг гаргаж баталгаажуулсан байна. Үүнд:

2.1. Хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн нөөцийг хүний тоогоор бүрдүүлэн, сэжигтэй тохиолдолд өмсөж, холбогдох арга хэмжээг авна. (Нэг удаагийн малгай, халад, нүдний шил, нүүрний хамгаалалт, амны хаалт, шүүлтүүртэй амны хаалт, хормогч, бээлий, усны гутал, улавч)

2.2.Хувийн хамгаалах хувцас, хэрэгсэлд тавигдах шаардлагыг хангасан байх бөгөөд тухай бүрд нөхөн, хангалтыг хийнэ.

2.3.Эрүүл мэндийн хяналтын цэг нь үйлчлүүлэгчид зориулсан амны хаалт, гарын эрүүл ахуй сахих (гар угаах, халдваргүйжүүлэх) боломжийг бүрдүүлсэн байна.

2.4.Халдваргүйжүүлэх бодисын нөөцийг бүрдүүлж, холбогдох зөвлөмж, зааврын дагуу орчны цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг хийнэ.

2.5.Сэжигтэй тохиолдолд хэрэглэх халдваргүйжүүлэх бодисыг найруулан бэлтгэж шалган нэвтрүүлэх цэгт хүргэсэн байна.

2.6.Эрүүл мэндийн хяналтын цэг нь шаардлагатай тохиолдолд нэмэлт сэргийлэлтийн арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан байна.

2.7.Эмнэлгийн гаралтай хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэн ажиллана.

2.8.Хяналтын цэгт үүрэг гүйцэтгэх эрүүл мэндийн ажилтнууд холбогдох сургалтад хамрагдсан байх бөгөөд мэргэжил арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажиллана.

2.9.Хяналтын цэгт ажиллах эмч, эмнэлгийн ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцуулан, гарын үсгээр баримтжуулна.

3.Шалган нэвтрүүлэх товчоонд ажиллаж буй эмч, эмнэлгийн мэргэжилтний унаа, хоолны зардлын асуудлыг тухайн дүүргийн эрүүл мэндийн төв болон бусад холбогдох байгууллага хамтран хариуцна.

Дөрөв:Халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүйтгэлд холбогдох байгууллагуудын ажилтан, албан хаагчдын эрх, үүрэг

4.1.Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтний үүрэг.

4.1.1.Тухайн цэгээр нэвтэрч буй тээврийн хэрэгсэл, түүгээр зорчиж буй иргэд хэрвээ өмнөх цэгүүдэд хяналт тандалтад хамрагдаагүй бол хүн тус бүрийг эрүүл мэндийн хяналтад хамруулна. Харин өмнөх цэгүүдэд үзлэгт хамрагдсан бол үзлэгийн хуудастай танилцан мэдээлэл авч үзлэг хийх шаардлагатай эсэхийг шийдвэрлэнэ.

4.1.2.Үзлэг эхлэхээс өмнө зорчигчдод шинэ коронавирусын халдварын сэжигтэй тохиолдлыг илрүүлж буй үйл ажиллагааны талаар танилцуулан, үнэн зөв мэдээлэл өгөхийг сануулж ажиллана.

4.2.Эрүүл мэндийн хяналт тандалтыг дор дурдсан аргачлалаар явуулна.Үүнд:

4.2.1.Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан шинэ коронавирусын халдварын сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар эхэлнэ. Асуумжийн дагуу бүх зорчигчдоос мэдээлэл авна.

4.2.2.Тухайн тээврийн хэрэгслээр зорчиж буй иргэн тус бүрийн биеийн халууныг үзэх бөгөөд зайнаас хэмжигч халууны шилийг ашиглан зорчигчийн дух, чих, эгэм орчимд хэмжинэ;

4.2.3. Зорчигчдын биеийн халууныг үзэхдээ амны хаалтыг зүүж, бээлий өмссөн байх ба хяналт тандалт дууссаны дараа гар халдваргүйжүүлэлтийг тогтмол хийнэ.

4.3. Тээврийн хэрэгсэлд зорчиж буй иргэд өвчлөл гарсан оронд зорчоогүй, өвчтэй хүнтэй хавьтал болоогүй, халуунгүй, ямар нэгэн зовиургүй байгаа бол тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зөвшөөрнө.

4.4. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч “үгүй” гэсэн боловч 38 хэмээс дээш халуурсан шинж тэмдэг илэрвэл эмнэл зүйн хуудсыг бөглүүлэн 3-аас дээш асуултад “тийм” гэж хариулсан бол гэрийн хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, амны хаалт зүүлгэж, эмнэлэгт хандахыг зөвлөн нэвтрүүлнэ.

4.5. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч “тийм” гэсэн боловч үзлэгээр халуунгүй, зовиургүй бол гэрийн хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, 14 хоног өөрийгөө хянах, шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хандахыг зөвлөн нэвтрүүлнэ.

4.6. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч “тийм” гэсэн болон 38 хэмээс дээш халуурсан шинж тэмдэг илэрвэл сэжигтэй гэж үнэлэн эмнэл зүйн асуумж бөглүүлнэ. Ингэхэд 3-аас доош асуултад “тийм” гэж хариулсан бол амны хаалт зүүхийг зөвлөн, гэрийн хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, 14 хоног өөрийгөө хянах, шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хандахыг зөвлөн нэвтрүүлнэ.

4.7. Хэрвээ тухайн зорчигч халдвар гарсан орноор зорчсон, өвчтэй хүнтэй хамт байсан өгүүлэмжтэй ч түүнээс хойш 14-өөс дээш хоног өнгөрсөн бол түүнийг сэжигтэй тохиолдолд тооцохгүй.

4.8. Сэжигтэй тохиолдлыг тодорхойлох асуумжаар зорчигч “тийм” гэсэн болон 38 хэмээс дээш халуурсан шинж тэмдэг илэрвэл сэжигтэй гэж үнэлэн эмнэл зүйн асуумж бөглүүлнэ. Ингэхэд 3-аас дээш асуултад “тийм” гэж хариулсан бол уг зорчигчид амны хаалт, бээлий өмсүүлэн зорчигчдоос нэг метрийн зайд тусгаарлана.

4.9. Тухайн зорчигчид нэг метрээс ойр байрлаж байсан хүмүүсийг хавьтал гэж үзэн мөн амны хаалт зүүлгэн эмнэл зүйн асуумжийг бөглүүлж гэрийн хаяг, холбоо барих утсыг тэмдэглэн авч, 14 хоног өөрийгөө хянах, шинж тэмдэг илэрвэл эмнэлэгт хандахыг зөвлөн явуулна.

4.10. Сэжигтэй тохиолдол илэрсэн талаар ХӨСҮТ-ийн 80086829, ЗӨСҮТ-ийн 70284393 дугаарын утаснуудад яаралтай мэдээлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авна.

4.11. Сэжигтэй зорчигч, хавьтлын мэдээллийг хүснэгтийн дагуу үнэн зөв, бодитойгоор тэмдэглэнэ.

4.12. Сэжигтэй зорчигчийн биеийн байдалд эрэмбэлэн ангилалт хийж, шаардлагатай тохиолдолд яаралтай болон амилуулах суурь тусламжийг стандартын дагуу үзүүлж, яаралтай тусламжийн хуудсыг 2% хөтөлж, нэг хувийг шилжүүлэн авч буй эрүүл мэндийн байгууллагын эмчид өгнө.

4.13. Сэжигтэй тохиолдол илэрсэн тээврийн хэрэгсэл хэрвээ алслагдсан байрлалд байгаа тохиолдолд зорчигчоо тээвэрлэн баруун талаас ирж байгаа бол Драгон төвд, зүүн талаас ирж байгаа бол Баянзүрхийн товчоо, хойд талаас орж ирж

байгаа бол Зунжин худалдааны төвд тус тус ирж зорчигчоо буулгахгүйгээр ХӨСҮТ, ЗӨСҮТ-ийн баг иртэл хүлээнэ. Сэжигтэй тохиолдол илэрсэн тээврийн хэрэгслийг тухайн шалган нэвтрүүлэх товчоонд ажиллаж байгаа Цагдаагийн байгууллагын алба хаагч дагуулан явж хүлээлгэн өгөх үүрэгтэй.

4.14.Хэрвээ Багануур, Налайх, Багахангай дүүргийн шалган нэвтрүүлэх цэгт сэжигтэй тохиолдол илэрвэл дүүргийн эмнэлгийн халдвартын тасагт тусгаарлан, сорьц авч ХӨСҮТ-д илгээнэ.

4.15.Дээрх төвүүдэд ирсэн зорчигчдыг ХӨСҮТ-ийн баг хүлээн авч тусламж үйлчилгээ үзүүлэх ба ЗӨСҮТ-ийн баг нь тухайн тээврийн хэрэгсэлд ариутгал, халдваргүйтгэлийг хийнэ.

4.16.Сэжигтэй тохиолдол гэж үзсэн зорчигчийг шилжүүлсний дараа тусгаарласан байр, хяналт шалгалтын цэгт эцсийн халдваргүйжүүлэлтийг хлор агуулсан уусмалаар хийнэ.

4.17.Шинэ коронавирусын халдвараас сэргийлэх талаар зөвлөмж, сэрэмжлүүлгийг иргэдэд, тээврийн хэрэгслийн жолооч нарт тарааж, сурталчилна.

4.18.Хэрвээ сэжигтэй тохиолдлын талаар өмнө нь мэдээлэл авсан бол эрүүл мэндийн ажилтан хувийн хамгаалах хувцсыг бүрэн өмсөж тухайн тээврийн хэрэгсэлд орон асуумж судалгааг аван, үзлэг хийж, тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

5.Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд ажиллаж байгаа бусад байгууллагын ажилтан, албан хаагчдын үүрэг.

5.1.Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд үүрэг гүйцэтгэх алба хаагч амны хаалт, бээлий тогтмол хэрэглэх, хувийн ариун цэвэр сахих, гарын ариутгалыг тогтмол хийх.

5.2.Засгийн газрын 2019 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, шалгаж буй бүх тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтыг тасралтгүй зохион байгуулах.

5.3.Сэжиг бүхий тохиолдолд хувийн хамгаалах хувцсыг өмсөж тээврийн хэрэгслийг хамгаалалтад авч дээд удирдлагад мэдэгдэх.

5.4.Сэжигтэй зорчигч илэрсэн тохиолдолд тээврийн хэрэгсэл, ачаа бараанд хүрэхгүй халдвар хамгаалалтын дэглэм, аюулгүй ажиллагааг сайтар мөрдөж ажиллах.

5.5.Шалгах бүртгэх товчоодод үүрэг гүйцэтгэж байгаа бусад байгууллагуудын ажилтан, албан хаагчид нь түр ажлын байранд эрүүл мэндийн байгууллагаас ажиллаж байгаа эмчийн заавар, зөвлөмжийн дагуу ажиллах.

5.6.Улаанбаатар хот руу нэвтэрч буй тээврийн хэрэгслийг зогсоож шалгах, эрүүл мэндийн байгууллагын ажилтны шинэ коронавирусын халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, хийх нөхцөл бололцоогоор хангах.

5.7.Сэжигтэй тохиолдол илэрсэн үед тухайн хүнтэй ойртож ажиллах шаардлага гарвал хамгаалах хувцсыг зааврын дагуу мэргэжлийн ажилтны хяналтад өмсөж, мэргэжлийн байгууллагад дэмжлэг үзүүлж, хэв журам сахиулах.

ЗОРЧИГЧИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН АСУУМЖ

1. Овог.....
2. Нэр.....
3. Хүйс Эр Эм /доогуур нь зурна уу/
4. Иргэншил.....
5. Регистрийн дугаар.....
6. Машины дугаар.....
7. Гэрийн хаяг.....
8. Утасны дугаар.....
9. Шаардлагатай үед холбоо барих хүний нэр, утасны дугаар
.....
10. Сүүлийн 14-21 хоногт зорчсон улс.....
11. Танд дараах шинж тэмдэг илэрч байвал + тэмдэг тавина уу?

№	Илэрсэн шинж тэмдэг	+ -		Илэрсэн шинж тэмдэг	+ -
1	38 ⁰ С-ээс дээш халуурах		8	Хэвлийгээр өвдөх	
2	Толгой өвдөх		9	Бөөлжих	
3	Булчингаар өвдөх		10	Суулгах	
4	Нүд улайх		11	Чичрэх	
5	Хоолой өвдөх		12	Арьсны тууралт	
6	Ханиалгах		13	Унтаа байдалд	
7	Хамраас нус гоожих		14	Бие сулрах	

12. Сүүлийн 14-21 хоногт халдварт өвчний сэжигтэй болон өвчтэй хүнтэй ойр байсан уу?
Тийм Үгүй /доогуур нь зурна уу/
13. Сүүлийн 7-14 хоногийн хугацаанд эм/антибиотик/ хэрэглэсэн үү?
Тийм Үгүй /доогуур нь зурна уу/
14. Мэдүүлэг авсан Он.....сар.....өдөр.....цаг.....минут.....
15. Зорчигчийн гарын үсэг.....



Нийслэлийн Засаг даргын 2020 оны
0-дугаар сарын 06-ны өдрийн
АН.Б.Б. 2 дугаар хавсралт

Нийслэлийн авто тээврийн шалган нэвтрүүлэх байнгын ажиллагаатай товчоонд шинэ
коронавирусын халдвараас сэргийлэх, илрүүлэх, хяналт, тандалт, халдваргүүтгэл хийх хуваарь

№	Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоо	Байршил	Нийслэлийн Эрүүл мэндийн газар	Нийслэлийн Онцгой байдлын газар	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар	Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, ТЦА-ны ЗЦГ
1	Хонхор	Налайх дүүрэг	2-3	1	1	3
2	Өлзийт /Айдсын даваа/	Хан-Уул дүүрэг	2-3	1	1	3
3	Эмээлт	Сонгинохайрхан дүүрэг	2-3	1	1	3
4	Баруун туруун	Сонгинохайрхан дүүрэг	2-3	1	1	3
5	Гүнтийн даваа	Чингэлтэй дүүрэг	2	1	1	3
6	Морингийн даваа	Хан-Уул дүүрэг	2-3	1	1	3
7	Багахангай	Багахангай дүүрэг	2	-	-	1
8	Хэрлэнгийн гүүр	Багануур дүүрэг	2-3	-	-	1